



**“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2026.02.06

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /”ЗТХТ” ТӨҮГ/-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

”ЗТХТ” ТӨҮГ-ын үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **81.4%**-тай үнэлэгдлээ. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

| Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц зорилтот түвшин | | | | Хэрэгжилтийн хувь |
|--------------------|---------------------------------------|---|-------------------------------------|----------------------------------|-------------------|
| | 85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй” | 60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа” | 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” | 0-29 хувь буюу “үр дүн гараагүй” | |
| 10 | 3 | 5 | 1 | 1 | 74.1% |

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

| Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц зорилтот түвшин | | | | Хэрэгжилтийн хувь |
|--------------------|---------------------------------------|---|-------------------------------------|----------------------------------|-------------------|
| | 85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй” | 60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа” | 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” | 0-29 хувь буюу “үр дүн гараагүй” | |
| 5 | 3 | - | 2 | - | 76.5% |

2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

| Нийт | Үүнээс | | | | Хэрэгжилтийн хувь |
|------|--------|-----------------|----|------------------|-------------------|
| | 100% | Хэрэгжих шатанд | 0% | Хугацаа болоогүй | |
| 84 | 61 | 20 | 3 | - | 88.0% |

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

| Нийт заалт | Үүнээс | | | | | Хэрэгжилтийн хувь |
|------------|-----------|-----------------|-------------|------------------|--------------------|-------------------|
| | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй | Хэрэгжих боломжгүй | |
| 3 | 2 | 1 | - | - | - | 83.3% |

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

| Нийт заалт | Үүнээс | | | | | Хэрэгжилтийн хувь |
|------------|-----------|-----------------|-------------|------------------|-----------------|-------------------|
| | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | |
| 15 | 12 | - | - | 3 | - | 100% |

2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

| Нийт заалт | Үүнээс | | | | | Хэрэгжилтийн хувь |
|------------|-----------|-----------------|-------------|------------------|-----------------|-------------------|
| | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | |
| 3 | 2 | 1 | - | - | - | 83.3% |

2.7. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

| Д/д | Үзүүлэлтийн бүлэг | Үнэлгээ (хувь) |
|------------|---|----------------|
| 1 | Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 64.4 |
| 2 | Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 42.9 |
| 3 | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 49.0 |
| 4 | Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал | 52.8 |
| 5 | Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 37.5 |
| Дүн | | 51.1 |

2.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

| Мэдээлэл оруулах тоо | Мэдээлэл оруулсан тоо | Үүнээс: | | | Гүйцэтгэлийн хувь |
|----------------------|-----------------------|-------------|----------|-------------|-------------------|
| | | Хугацаандаа | Хоцорсон | Мэдээлээгүй | |
| 180 | 180 | 180 | - | - | 100% |

Гурав. Үнэлэлт, дүгнэлт
Төлөвлөлтийн байдал:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д зааснаар “Шалгуур үзүүлэлт”-ийг “Зорилтот түвшин”-тэй уялдуулж төлөвлөөгүй. (1.22, 3.1, 3.8, 4.5, 4.9, 4.13, 4.15, 6.1-6.14).

Хэрэгжилтийн байдал:

1) “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ ын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 81.37 %-тай байна.

2) Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтүүдийг арга хэмжээний агуулгаар нь авч үзвэл:

- Авто замын барилгын ажлын гүйцэтгэл:

Гүйцэтгэгч байгууллагын хүн хүч, машин механизмын хүрэлцээ, хуваарилалт зэрэг ажлын зохион байгуулалттай холбоотой төсөл арга хэмжээ.

Улсын төсөвт тавигдсан санхүүжилт болон ажлын тоо хэмжээтэй холбоотой төсөл арга хэмжээ.

Авто замын трассд орсон газар чөлөөлөлт, инженерийн шугам сүлжээний асуудлыг орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагууд шийдвэрлээгүй төсөл арга хэмжээ.

- Стандарт, норм, дүрэм, журам шинэчлэн батлуулах болон техникийн баримт бичгийн хүртээмжийг сайжруулах ажил буюу зохион байгуулалт болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, цаг хугацааны хувьд удааширалтай арга хэмжээ.

- Сургалт зохион байгуулах болон эрсдэлийн үнэлгээ хийх арга хэмжээ буюу байгууллагын дотоод зохион байгуулалттай холбоотой хэрэгжээгүй арга хэмжээ.

- *Нээлттэй мэдээллийн ил тод байдал:*

Зарим үзүүлэлтийн холбогдох баримт материал, фото зураг, холбоос зэргийг хавсралтаар байршуулаагүй болон дутуу байршуулсан учраас 51.1 хувьтай үнэлэгдсэн байна. Тухайлбал, хүний нөөцийн мэдээлэл болон төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үзүүлэлтээр 42.86% болон 48.96%-иар үнэлэгдсэн байна.

3) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 84 арга хэмжээний хэрэгжилт 88.0% байна. Үүнээс 96.4 % нь хүрэх түвшиндээ хүрсэн болон хүрэх шатандаа, 3.6% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

- 4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

| Зорилт | Зорилтот түвшин | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь |
|--|--|--------------------|-------------------|
| Зорилт 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, гүүрийн барилгын ажилд техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. | Нийт 173.98 км урт авто замыг улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө. | 22 | 86.9 |
| Зорилт 2: Авто замын барилга угсралт, засвар арчлалтын материалд сорилт, шинжилгээг хийж, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлнэ. | 2150 удаагийн туршилт, шинжилгээ хийнэ. | 7 | 92.1 |
| Зорилт 3: Олон улс, улсын чанартай 14.921 км авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлнэ. | Олон улс, улсын чанартай 14,921 км авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлнэ. | 8 | 78.1 |
| Зорилт 4: Захиргааны болон хүний нөөцийн манлайллыг хэрэгжүүлж, эрхзүйн зохицуулалтыг ханган санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг зохицуулж, хэрэгжүүлнэ. | Төлөвлөгдсөн ажил, арга хэмжээний хэрэгжилт, өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэнэ. | 19 | 92.9 |
| Зорилт 5: Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативыг шинэчлэн сайжруулж, боловсронгуй болгоно. | 300 зураг төслийн баримт бичигт магадлал хийж, 21 стандарт, 8 норм батлуулна. | 6 | 66.7 |
| Зорилт 6: Төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулж, түргэн шуурхай байдлыг хангуулна. | Шинээр 1 төлбөр авах цэгийг байгуулж, 25 төлбөр авах цэгийг цахимжуулна. | 14 | 88.6 |
| Зорилт 7: Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх, инновац нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 3 чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийнэ. | 8 | 100 |

5) Өмнөх ХШҮ хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал:

1. Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг эрчимжүүлж, хугацаанд нь дуусгах;

Биелэлт: Зам, тээврийн яамны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/289 дугаартай тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу арчлалт урсгал засварын ажлыг бүрэн дуусгаж, 42,585,405,746 төгрөгийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, Зам, тээврийн яаманд хүргүүлсэн байна.

2. Норм, нормативын сангийн төлөвлөлтийг сайжруулж, тухайн онд хэрэгжих ажил үйлчилгээг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Хяналтын зөвлөлд хэрэгжилтийг тайлагнаж ажиллах;

Биелэлт: “Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан Сангийн удирдах зөвлөлийн 2025.07.04-ны өдрийн хурлаар батлуулсан.

Сангийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 87 төсөл тусгагдсан. Үүнээс он дамжин хэрэгжиж буй 45 төсөл, шинээр хэрэгжүүлэх 32 төсөл, үйл ажиллагааны зардал 10 төсөл тусгагдсан. Он дамжин хэрэгжиж буй 45 төсөл арга хэмжээнээс 3 төсөл бүрэн дууссан, 16 төсөл нь батлагдах шатанд, 23 нь эцсийн болон дуусах шатанд байгаа бол 4 нь дунд шатанд хэрэгжиж байна.

Шинээр хэрэгжүүлэх 32 төслөөс эхлэлийн шатанд 1 төсөл, дунд шатанд 2 төсөл, үлдсэн 26 төсөлд тендерийн сонгон шалгаруулалтыг зарласан.

Сангийн ажиллах журмын шинэчилсэн төсөлд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь “Монгол Өмгөөлөл” хуулийн фермтэй хамтран дахин саналыг тусган шинэчлэн боловсруулсан.

3. Авто замын барилга, шинэчлэлт, засвар, арчлалтын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах журмыг шинэчлэн боловсруулж, Зам, тээврийн сайдаар батлуулж мөрдөх;

Биелэлт: “Авто замын барилга, шинэчлэлт, засвар, арчлалтын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, холбогдох газар хэлтсээс санал авч нэгтгэн сайжруулж байна.

4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч хяналтыг сайжруулах;

Биелэлт: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй.

5. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж, ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах.

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 бүлгийн 60 үзүүлэлтээс тус байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах 33 шалгуур үзүүлэлтээр хэрэгжилт 51.09 хувьтай үнэлэгдсэн.

6. Хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:

➢ Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

Биелэлт: Суурь түвшинг буруу тавьсан. (1.3,), шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин уялдаагүй (1.22, 3.1, 3.8), шалгуур үзүүлэлтийг буруу тодорхойлсон (4.5, 4.9, 4.13, 4.15, 6.1-6.14).

➤ Ил тод байдлыг хангах, шилэн дансны тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь мэдээлэх, ХАБЭА-ийн ажлууд зэрэг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт болгон дээр давхацуулан тусгасан ажлуудыг нэгтгэх;

Биелэлт: Дээрх тайлангуудыг хугацаанд нь мэдээлсэн боловч хавсралт файл, холбогдох баримт материал дутуу байршуулнаас хангалтгүй үнэлэгдсэн.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Бодлогын бичиг баримтуудад тусгасан хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, арга хэмжээний ажлыг эрчимжүүлэх;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 84 арга хэмжээнээс хэрэгжээгүй 3 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн ч бүрэн дуусгаж чадаагүй 20 арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

3. Техник технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн мэдээг төсөл арга хэмжээ тус бүрээр гаргаж, нэгтгэн улирал тутам тогтоосон хугацаанд Авто замын бодлого зохицуулалтын газраар хянуулж, Салбарын хяналт-шинжилгээ, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлж байх;

4. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д зааснаар байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах шалгуур үзүүлэлтэд хамаарах мэдээллийн хавсралт файл, фото зураг, холбоосыг бүрэн гүйцэт байршуулах;

5. Цаашид эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт материалын хамт бүрэн тайлагнаж хэвших;

6. Байгууллагын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллах;

7. Байгууллагын эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллах;

8. 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийн анхаарах.

Үүнд:

➤ Бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээнүүдийг байгууллага болон албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах;

➤ Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх;

➤ Төсөл, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах;

9. Цаашид биелэлтийн тайлан ирүүлэхдээ биелэлтэд тавигдах шаардлагуудыг мөрдөж биелэлтийг алдаагүй, тоо баримттай, үнэн зөв боловсруулж, хянан баталгаажуулах зэрэг болно.

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

| № | Үзүүлэлт | | Төсөл, арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь | Жинлэсэн хувь |
|-------------|---------------------------------------|--|---------------------------|-------------------|---------------|
| 1 | Бодлогын үрдүн | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 10 | 74.1 | 20 |
| 2 | | Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 8 | 75.6 | 20 |
| 3 | Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ) | Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт | 84 | 88.0 | 20 |
| 4 | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 3 | 83.3 | 20 |
| 5 | | Сайдын тушаалын хэрэгжилт | 15 | 100 | 10 |
| 6 | | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт | 3 | 83.3 | 10 |
| 7 | Чадамжийн үнэлгээ | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт | 33 | 51.09 | 10 |
| 8 | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 180 | 100 | 10 |
| 9 | | Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт | - | - | - |
| 10 | | Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | - | - | - |
| Нийт | | | 336 | 81.37 | |

---oOo---